

## ӨНДӨР ГЭГЭЭН ЗАНАБАЗАРЫН БАЙГУУЛСАН ТӨГСБАЯСГАЛАНТ НОМЫН ИХ ХҮРЭЭ УРАН БАРИЛГЫН ДУРСГАЛ БОЛОХ НЬ

О.Доржготов, магистр, МУБИС

### Abstract

Öndör Gegeen Zanabazar was born in 1635, was the son of the Tusheet Khan Gombodorj and in 1639, named him as the first Bogd Jebtsundamba Khutuktu, the spiritual head of Tibetan Buddhism in Mongolia. He started to study Buddhist philosophy from his early ages. And from 1649 to 1654, he studied in Tibet. During this time, he deepened his knowledge about Buddhist core schools and philosophies, also mastered creation of Buddhist arts. In 1654, right after he came back from his study in Tibet, he started to build “Great Monastery of Tugsbayasgalant” which was the Centre of Tibetan Buddhism of Khalkha Mongols. He spent over 32 years for its accomplishment. Unfortunately, during the war between of Khalkha and Oirat Mongols, this monastery destroyed and burnt down by Dzungar khanate`s army.

Between the 2013-2015, Institute of History, Mongolian Academy of Sciences did archeological excavation and research for remains of the monastery, they found over 1300 historical valuable items. The few important examples of their findings such as first time ever found masterpieces of Five Buddha Families (objects made by ceramic), pieces of big Buddhist sculptures, full set of armor of Mongolian warrior, eight auspicious symbols and Buddha statue made by copper and among other. Öndör Gegeen Zanabazar was a multi-talented man, he was a great sculptor, painter, linguist, spiritual political leader of Mongolia and also, he was an astonishing architect and a city planner, too. In fact, the “Great Monastery of Tugsbayasgalant” was the greatest example of masterpiece created by Öndör Gegeen Zanabazar which he dedicated 32 years of his life and his intelligence to its creation and accomplishment.

### Түлхүүр үг

Анхдугаар богд, Цагаан хот, Халх-Ойрадын дайн, Сарьдагийн хийдийн туурь, малтлага, хосгүй үнэт олдворууд

### Удиртгал

Монгол оронд Буддын шашны нэгэн гол урсгал болох Шарын шашин XVI зуунаас түгэн дэлгэрч, 1586 онд Абатай сайн хан Эрдэнэзуу хийдийн суурийг тавьсан байдаг. Тэр цагаас хойш 350 гаруй жил шарын шашин улам хүчтэй дэлгэрч, “1937 оны байдлаар Монгол даяар нийтдээ 750 гаруй хүрээ, хийдэд 4000 шахам сүм, дуган, дацан байгуулагдаж, тэдгээрт 100 мянга хол давсан эрчүүд шавилан сууцгааж” (Монгол улсын түүх, 2003, х.211) байжээ. Шарын шашин ийнхүү хөгжин мандахад үнэтэй хувь нэмэр оруулсан хүн бол Халхын Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазар (1635-1723 он) юм. Тэрбээр Чингис хааны алтан ургийн удам Батмөнх даян хааны 7 дахь үе Түшээт хан Гомбодоржийнд 1635 оны Хөхөгчин гахай жилийн намрын тэргүүн сарын 25-нд тэр үеийн Түшээт ханы нутаг Усан зүйлийн хойд “Див” хэмээх газарт (өнөөгийн Өвөрхангай аймгийн Есөнзүйл сум О.Д) мэндэлсэн агаад улмаар “1639 онд 5 настайд нь Анхдугаар Богд Жавзандамба хутагтын хувилгаанаар тодруулан, Монголын шарын шашны тэргүүнд өргөмжилсөн” (Болдбаатар Ж, 2010, х.32) байдаг.

Миний бие энэхүү Төгсбаясгалант Номлол Бүтээлийн хүрээний талаар аман болон бичмэл

түүх, холбогдох ном, зохиол, судалгааны эх сурвалжид судалгаа хийж, археологийн малтлагаар илэрсэн олдворууд, монгол, түвд, хятад хийцийн сүм дуганы барилгын талаар харьцуулан судлах зорилт тавин, энэхүү өгүүллийг бичлээ.

### Үндсэн хэсэг

Өндөр гэгээн Г.Занабазар бага наснаасаа бурхан шашны сургаал номлол, зан үйл, дэг ёсонд суралцаж улмаар “1649 оны Цагаан барс жил Түвд оронд айлчилж Далай лам Агваанлуvsсанжамцад бараалхан шашны их бага таван ухааны онолыг гүнзгийрүүлэн судалж, шүтээн урлахуйн ухаанд төгс боловсрон” (Дамдинсүрэн Д, 1995, х.5) 1654 онд буцаж иржээ. Залуу хутагт эх нутагтаа ирээд номын хүрээ хийд, шашны сургуулийг олноор байгуулж, шажин соёлыг ард олны дунд түгээн дэлгэрүүлэхийг хичээж эхэлсэн байдаг. Занабазар шарын тэргүүн төдийгүй уран барималч, зураач, хэл шинжлэгч зэрэг олон талын авьяастай, шашин, төр, урлагийн зүтгэлтэн, их соён гэгээрүүлэгч хүмүүн байсан нь түүхэн эх сурвалж болон бүтээл туурвилаас нь тодхон харагддаг. Тэрээр Монголын дүрслэх урлагийн түүхэнд өөрийн гэсэн дэг сургуулийг бий болгож, сор болсон гайхамшигт

бүтээлүүдийг бүтээсэн нь өдгөө “Монгол улсын түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлсийн жагсаалтад зүй ёсоор бүртгэгдэж, дэлхийн соёлын өвийн нэгээхэн хэсэг болжээ” (Оюунбилэг 3, 2010, х.22).

Өндөр гэгээн Занабазар нь академич Бямбын Ринчен нэрлэснээр “Уран барилгатан” (Ринчен Б, 1956, х.29) байсан агаад бурхны шажин соёлыг ард олонд түгээх болон шашны урлал, бүтээл туурвих зориулалтаар сүм хийдүүдийг Монгол орон даяар олноор барьж байгуулах үйл хэргийг эхлүүлж байжээ. Тэрбээр өөрийн биеэр бурхан шүтээн урлан бүтээхээс гадна хүрээ хийдийг өөрийн зохиосон хэв загвараар барьж байгуулах ажлыг гардан хийж байсан юм. Тухайлбал; “Өндөр гэгээний удирдан барьж байгуулсан Сарьдагийн хийдийн Цогчин дуганы янз хэлбэрийг ийм янзтай хийнэ хэмээн зааварлаж 108 баганатай байх ёстой. Хэрвээ лам хувраг нарын тоо нэмэгдэх тэр цагт нэгэн нуруу нэмж байвал байр хэлбэр үл алдагдана” (Оюунбилэг 3, 2010, х.23) хэмээсэн байдаг. Түүний шууд оролцоо санаачилгаар 1648 онд Шанхын Баруун хүрээ буюу Рибүгигжгандандэгчэнлин, 1651 онд Дубхан буюу Бүтээлийн хийд, 1654 онд Төгсбаясгалант Номлол Бүтээлийн хүрээ буюу Рибогэжай-ганданшадувлин, 1706 онд Батцагаан цогчин дуган зэрэг хүрээ, хийдийг үүсгэн бариулжээ.

### **Номын их хүрээ байгуулагдсан түүх ба түүхэн эх сурвалжууд**

Халхын шашны нэрт зүтгэлтэн Зая бандид Лувсанпэрэнлэй өөрийн багш Өндөр гэгээн Занабазарын намтрыг 1698-1702 онд түвд хэлээр бичиж дуусгасан “Гэгээн толь” хэмээх бүтээлдээ багтаан оруулсан байдаг аж. Дээрх бүтээлийн “Богд Жавзандамбын ердийн товч намтар” хэмээх зохиолд Сарьдагийн хийдийн түүхэнд холбогдох анхдагч эх сурвалж байдаг ажээ. Уг сурвалжид “Үй Зан орнуудад очихдоо сургуульд шавилах тухайгаа Банчин Богдын гэгээнд айлтгахад - Чи энд шавилан сууснаас Монгол орондоо хуврагийн аймгийг байгуулбаас шажин амьтанд илүү тустай болно хэмээн айлдсан болой. Энэ ёсоор Жалба хэмээх модон морин (1654) жил Хэнтий хан хэмээх газар Рибогэжээлин хэмээх хийдийг байгуулж эхлэв” (Бира Ш, 1995, х.6) хэмээн өгүүлжээ. Мөн Их хүрээний нэрт бурхан зураач асан Дамдинсүрэн энэ тухайд “Өндөр гэгээн Г.Занабазар бээр 20 настай байх үедээ “Рибогэжай-ганданшадувлин буюу Дэлгэр Өлзийт уулын Төгсбаясгалант Номлол Бүтээлийн Хүрээ” хэмээх хийдийг Хэнтий уулын өвөрт өөрөө шинээр зохион байгуулсан аж. Мөн Өндөр гэгээний хийдчин гэдэг тусгай барилгачин ардуудыг гаргаж, 1654 оны Хөх морин жил хийд бариулах ажлыг эхэлжээ” (Дамдинсүрэн

Д, 1995, х.5) хэмээн дурдсан байдаг. Эдгээр модны дархчуул, барилгачид нь “Хийдчиний отог” болж 1921 оны хувьсгалыг хүртэл үе улиран суурьшиж байжээ. Эндээс үзэхэд Өндөр гэгээн Занабазар Түвдээс буцаж ирсний дараахан буюу 1654 онд Хэнтий ханы өвөрт Рибогэжээлин буюу бүтэн нэрээр Рибогэжай-ганданшадувлин хэмээх хийдийн эх суурийг тавьсан нь тодорхой харагддаг байна.

Мөн үүнээс арай хожуу үед зохиогдсон “Богд Жибзундамбын анхны төрлийн нэр оршивой” хэмээх сурвалжид “Эеэр засагчийн арван нэгдүгээр он хөх морин жил (1654) Богд Жибзундамбын гэгээнтэн Халхын газарт Хэнтэй уулын өвөрт шарын шажныг бадруулах Рибогэжай-ганданшадувлин хэмээх Номын Их Хүрээ байгуулав” (Жавзандамбын анхны төрлийн нэр оршвай, он т-бус, х.9) хэмээсэн байдаг.

Дээр дурдсанчлан Занабазарыг 5-н настай байхад “Халхын долоон хошууны Хан ноёд хуралдан чуулж, түүнд Гэгээн цол өргөмжлөн, “Ширээт цагаан нуур” хэмээх газар Шар бөсийн өргөөг үүсгэн байгуулсан” (Жавзандамбын анхны төрлийн нэр оршвай, он т-бус, х.6) байдаг. Дээрх түүхэн эх сурвалжаас үзэхэд Өндөр гэгээнд байгуулж өгсөн тэрхүү Шар бөсийн өргөө нь Номын их хүрээ болон өргөжиж, 1654-1688 оны хооронд Хэнтий нурууны Сарьдаг уулын өвөрт төвлөрч байсан агаад түүнээс хойш 30 гаруй удаа бууриа сэлгэн нүүж, Их хүрээ, Богдын хүрээ, Нийслэл хүрээ, өнөөгийн Улаанбаатар хотын эх үндэс болжээ.

### **Номын их хүрээ байгуулах болсон учир шалтгаан**

Өндөр гэгээн Занабазар өөрийн үүсгэн байгуулсан Номын их хүрээгээ Орхон голын хөндийгөөс Хэнтий уулын өвөр тийш нүүлгэсэн тухай тодорхой хэдэн шалтгаан байдаг. Нэгд, өөрийн өндөр өвөг Автай Сайн ханы байгуулсан Эрдэнэзуу хийдээс зүүн тийш Эзэн Чингис хааны өлгий нутаг Хан Хэнтийн нуруунд газар шинжиж, байгалийн үзэмж төгс газарт Номын хүрээг байгуулсан байх талтай. Мөн түүнийг Түвдэд сурч байх үест нь Банчин Богд гэгээн бээр-Чи энд шавилан сууснаас Монгол орондоо буцаж, хуврагийн аймгийг байгуулбаас шажин амьтанд илүү тустай болно” (Бира, 1995, х.6) хэмээн айлдсан нь түүнд нөлөөлсөн байх талтай. Мөн тухайн Хүрээг байгуулсан газар орон нь хүн малын хөлөөс хол, онгон зэлүүд газар байдаг нь угтаа нямбо бясалгал хийх, номлол сургаал айлдах, шашны урлал бүтээл туурвихад гаднын аливаа нөлөөллөөс ангид, нам гүн орчинд төвлөрч ажиллахад тохиромжтойг бодолцсон болмуу хэмээн санагддаг. Хожим нь хүрээг нураагдсаны

хойно Занабазар бээр Дубхан хийдэд олон жил нямбо бясалгал хийн уран бүтээлээ туурвиж байсан байдаг. Эдгээр учир шалтгаанаас улбаалж Номын их хүрээг шилжүүлэн байгуулах нөр их ажлыг эхлүүлж, хуучин хүрээнээс буурь сахиж үлдсэн хэсэг дуганыг Баруун хүрээ хэмээн нэрлэх болсон агаад хожим нь Шанхын хийд гэх болов.

### Нэршил

Уг хийдийн нэршлийн тухайд тодруулахад анхлан Өндөр гэгээн Занабазар бээр өөрийн байгуулсан хийдэд түвдээр “Рибогэжай-Ганданшадувлин буюу Монголоор Дэлгэр Өлзийт уулын Төгсбаясгалант Номлол Бүтээлийн Сүм” хэмээх нэр айлдсан нь албан ёсны оноосон нэр нь байжээ. Харин хийдийн дийлэнх сүм дуганы гаднах өнгөнөөс улбаалж түмэн олонд “Цагаан хот” хэмээн дуудагдах болжээ. Өнөөдөр тус хийдийг байршиж байсан газраар нь буюу Хэнтийн нурууны салбар “Арцат Сарьдаг” уулийн өвөрт оршиж байснаас үүдэн “Сарьдагийн хийд” гэж нэрлэгдэх болов.

### Хүрээ байгуулсан газар орон

Өндөр гэгээн Занабазарын өөрийн биеэр залран, адисалсан газартаа 1654 оноос энэхүү Халхын Шарын шашны төв “Төгсбаясгалант Номлол Бүтээлийн хүрээ” буюу Сарьдагийн хийдийг үүсгэн байгуулсан агаад өнөөгийн Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг, Хан Хэнтийн нурууны салбаруулс болох Арцат Сарьдаг хайрхны өвөрт наран ургах зүгт харуулан байгуулагдсан хот байжээ. Газар зүйн байршил, тогтцын хувьд далайн төвшнээс 2665 метрт, хөвчийн өндөр уулын ой, тайгын бүсэд алсын бараа харагдахуйц, байгалийн үзэмж төгс хосолсон үзэсгэлэнт сайхан газарт хийдийн туурь балгас оршдог. Эргэн тойронд нь нарс, хус, хар мод, бургас битүү шигүү ургасан байх ба тууриас баруун тийш 100 гаруй метрт “Хийдийн нуур” хэмээх жижиг тунгалаг уст нууртай бөгөөд энэ нуураас “Хийдийн гол” эх авч “Туул” голд цутгадаг ажээ. Улаанбаатар хотоос баруун хойш 150 гаруй км, Эрдэнэ сумын төвөөс чанх хойшоо 90 гаруй км алс энэ газарт намаг балчиг, бартаа саад ихтэй тул автомашинаар очих аргагүй бөгөөд зөвхөн мориор юм уу явганаар очих боломжтой.

### Барьж байгуулсан он цаг, хугацаа

Тус хийдийг барьж байгуулсан хугацааны талаар түүхэн баримт эх сурвалжид үлдсэн байдаг. Тухайлбал, мөнөөх Зая бандид Лувсанпэрэнлэйн “Богд Жибзундамбын ердийн товч намтар”-т дурдахдаа “Дондув хэмээх шороон хонин (1679) жилийн өвлийн адаг сар би Монгол орондоо хүрч ирэв. Дагбо хэмээх төмөр мичин жилийн (1680)

зун энэхүү Богд гэгээнд мөргөхөөр ирэв. Хийдийн гадна талын ихэнхийг барьж дуусгаад бурхан шүтээнийг нь бүтээж байсан үе байв. Тэнд арваад хоног саатаж зарлиг авшиг айлтгав. Садба хэмээх гал барс жилийн (1686) зун Рибогэжалин хийдийн бурхан шүтээн бүтээсэнтэй зохилдуулж зарим лам нараар равнай хийлгэж соёрхов” (Бира Ш, 1995, х.17) хэмээн тодорхой өгүүлсэн байдаг аж. Үүнээс харахад Сарьдагийн хийдийг барих ажил өмнө дурдсан Модон морин жил буюу 1654 онд эхэлж, Төмөр бичин жил буюу 1680 оны зун гэхэд ерөнхий барилгын ажил шувтарч, Гал барс жил буюу 1686 он гэхэд бурхан шүтээнүүдийг бүтээж дууссанаар даруй 32 жилийн турш үргэлжилсэн болох нь тодорхой байна. Эндээс үзэхэд тухайн цагт алив томоохон хүрээ хийдийг бүрэн барьж, байгуулан дуусгахад ихээхэн хэмжээний хөрөнгө, зорь, хүн хүч, цаг хугацаа зарцуулдаг байсан нь илт юм. Зарим томоохон хийдүүдийн тухайд бол бүр 100-200 жилийн хугацаа зарцуулсан баримт ч байдаг ажээ.

### Халх Ойрадын дайн

Халх Ойрадын дайн 1696 онд дуусгавар болсноос уг хийд үндсэндээ орхигдон балгас болж үлдсэн бөгөөд хожуу уг хийдийг сэргээхээр оролдож байсан ч тодорхой үр дүнд хүрээгүй ажээ. Энэ талаар Зая бандид Лувсанпэрэнлэйн “Болор толь” хэмээх сурвалжид “Ойрад Халхын хоорондын дайны хөлд нэрвэгдсэн Номын хүрээг сэргээн босгож, Халхын шашны төв болгохын тулд шүтээн суваргануудыг нь сэлбэн, лам нарт зэд, пог, манз талбин олговой...” (Бира Ш, 1995, х.6) хэмээн тэмдэглэгджээ.

### Номын их хүрээнд хийгдсэн археологийн судалгаа

Ийнхүү тэртээ XVII зуунд үүсгэн босгосон Өндөр гэгээний гайхамшигт бүтээл туурвилын сор болсон энэ хот XX зууны эх хүртэл 230 гаруй жил хэний ч хөл хүрэлгүй хөвчийн ой тайгад хучигдан (200 гаруй жилийн өмнө Хангайн өндөр уулын бүсэд ойн захад тулган барьсан хүрээний туурь балгад он цагийн эргэлтэд ийнхүү битүү шигүү ой хөвч болон хувирчээ.О.Д) дарагджээ. Чингээд анхлан 1915-1916 онд П.А.Виттегээр удирдуулсан Хаант Орос улсын эрдэм шинжилгээний ангийнхан нутгийн иргэдийн туслалцаатайгаар Сарьдагийн хийдийн байгаа газрыг нээж илрүүлснээ тэмдэглэжээ. Үүний дараа 1923 онд Судар Бичгийн Хүрээлэнгээс судлаач Д.Бат-Очир, Оросын эрдэмтэн В.И.Лисовский нарын баг хийдийн ерөнхий төлөв байдлыг тогтоох ажлыг хийж, шинжлэх ухааны судалгаанд анхлан оруулжээ. Түүнээс хойш ахин судалгааны ажил хийгдэлгүй орхигдож байгаад 1995 онд ШУА-ийн

Түүхийн Хүрээлэнгээс Төв аймгийн Орон нутгийг судлах музейтэй хамтран хээрийн шинжилгээний анги зохион байгуулж, археологийн дэвсгэр зураг үйлдэн, зарим газар сорилтын малтлага хийсэн байдаг. Үүний үр дүнд Өндөр гэгээний оролцоо, санаачилгаар барьсан сүм хийдүүдийн дотроос цаг хугацаа, цар хүрээний хувьд томоохонд тооцогдох Номын их хүрээ мөн гэдэг нь нотлогдсон. Мөн хийдийг байгуулсан газрын байршил нь өвөрмөц онцлогтой болохыг тогтоосон байна.

2013 оноос ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн судлаачид “XVII зууны Монголын хот, суурин” төслийн хүрээнд тус хийдийн туурийн судалгааг шинэчлэн, баримт эх сурвалжийн болон аман түүхийн мэдээ баримтыг цуглуулж, судалгааг гүнзгийрүүлэхээр ажиллаж эхэлжээ. Улмаар ШУА-ийн Түүхийн хүрээлэн, ССАЖЯ, Богд Хааны Ордон Музей хамтран зохион байгуулсан авран хамгаалах малтлага судалгааны ажлыг 2013-2015 оны хооронд хийж эхэлсний үр дүнд тус хийдийн тууриас 1300 гаруй олдворыг илрүүлсэн байна. Тухайлбал: Урьд өмнө илэрч байгаагүй нарийн хийцтэй “язгуурын таван бурхад (*шавраар урласан*), асар том хэмжээтэй бурхдын шавар баримал, тал хивэнд цутгасан бурхдын шавар дүр, уран нарийн хийцтэй барилгын чимэглэл, ялтсан хуяг, дуулга, илд, цахиур буу, цагаан шаазан цом, тахил шүншгийн холбогдолтой алт, мөнгө, эг сонирхолтой эд өлгийн зүйлс, олдворууд олноор гарч иржээ. Өндөр Гэгээний хийц дэг сургуулийнх гэдэг нь хэнд ч танигдахаар ийм үнэ цэнэтэй олдворууд урьд нь ийм олноороо олдож байгаагүй бөгөөд тэдгээрийг сэргээн засварлах, судлах, сурвалжлах нөр их ажил эрдэмтэн судлаачдын өмнө үлдэж байна.

### **Номын их хүрээний төлөвлөлт, зохион байгуулалт**

Төгсбаясгалант Номлол Бүтээлийн хүрээ буюу Цагаан хот нь 11-н томоохон цогчин дуган, сүм, суваргууд, хэрмэн ханаар хүрээлэгдсэн байснаас одоогийн байдлаар 9-н томоохон барилгын туурь, 3-н суваргын туурь, чулуун хэрмийн үлдэц, чулуугаар зассан зам талбай бүхий гудмууд байгаа нь тогтоогдсон юм. Өнөөгийн байдлаар дээрх 9-н барилгын тууриас зөвхөн хамгийн томд тооцогдох Цогчин дуганы туурийг онцлон судалж, малтлагын ажлыг гүйцэтгэсэн байна. Мөн тус хүрээ байрлаж байсан газар нь дээр дурдсанчлан өндөр уулын энгэр, эгц налуу газар тул дуган хийдийн барилгуудыг барихдаа урьдаар тусгайлан зассан өндөр чулуун дэвсгэр, тавцанг бэлтгэдэг байжээ.

Дараа нь тэрхүү тэгш тавцан дээрээ зассан боржин чулуугаар суурь тавиад түүн дээрээ дуган дацангийн барилгаа барьдаг байв. Дээрх өндөр

чулуун дэвсгэр дээр буй сүм дуганд орохын тулд чулуун довжоо бүр нь 2 талаасаа өгсөн гардаг шаттай байжээ.

Тус хүрээний хэрмэн хана нь Эрдэнэзуу хийдийн суварган хэрэмтэй тун төстэй хэмжээ, хийц, бүтэцтэй баригдсан байх ба шороог дагтаршуулж далан босгож, байгалийн хад чулууг тэгшлэн, хоёр талаар нь нямбай жигд өрж, 1.5 м өргөнтэй 2 м өндөртэй (*зарим налуу газарт 3-4 м хүртэл өндөртэй байв.*) үндсэн хэрмэн ханаа босгосны дараа эцэст шавраар дэлдэж өнгөлөөд цагаан пайтуугаар будсан байсан нь өнөөдөр нураагүй үлдсэн хэрмэн хананы хэсгээс тодорхой харагдах ажээ. Хэрмэн хана нь голдоо өндөр довжоо бүхий дээвэртэй их дааман хаалгаар дотогш нэвтэрдэг байсан ба энэ хэсгээс зузаан модон хаалга, хаалганы нугас зэрэг олдвор олджээ. Хэрмэн хашаанд ормогц 100 гаруй м<sup>2</sup> газрыг бүхэлд нь зассан хавтгай чулуугаар шигтгэсэн талбайтай байжээ. Магадгүй энэ талбай нь цам харайх, сор залах, ном хаялцах шашны гол ёслол хийдэг газар нь байсан байх талтай.

Энэ талбайн хойно гадуураа 92x75 м хэмжээтэй хэрмэн хашаатай гол Цогчин дуганы туурь байсныг илрүүлэн энд малтлагыг үндсэн ажлыг эхлүүлжээ. Дуганы нуранги үлдэц, барилгын материал зэргээс үзэхэд Цогчин дуган нь ойролцоогоор 10 гаруй м өндөртэй, чулуун ханатай, дотроо 7-н тасалгаатай, 2 давхар, вааран дээвэртэй, Түвд хийцийн дуган байсан байх магадлалтай байна. Учир нь тухайн цаг үед ойролцоо баригдсан Дубхан, Шанх, Хөгнө тарнийн хийдүүд бүгд уг дугантай ижилхэн материалаар Түвд хийц загвартай баригдсан байдаг тул Цогчин дуганы хийц мөн адил байх нь гарцаагүй юм. Дуганы чулуун хананы нурангийн дээд хэсэгт салхивч цонх байсны ул мөр олдсон ба энэхүү цонхноос дээш хананы өндөр даруй 2 м гаруй байгаа нь уг барилга 2 давхар байсныг илтгэж байгаа аж.

Мөн 1-р давхарын дээвэр нь улбар шар вааран дээвэртэй бол дээд давхар нь алтан шаргал өнгөтэй вааран дээвэртэй байсны ул мөр олдсон байна. Тухайлбал нэг давхарын улбар шар дээврийн ваар нь тосгуур ба нөмрөг, нүүр ваараас бүрдэж байжээ. Эдгээр вааруудыг Өндөр гэгээний зохиосон соёмбо үсэг болон хүрдэн хээгээр чимэглэсэн байх нь сонирхол татдаг агаад тэднийг дуганы урд байрлах үүдний саравч болон дээвэрт ашигласан байжээ.

Харин 2 давхарын алтан шаргал өнгөтэй дээврийн нүүр ваар нь бухын нүүрний дүрс бүхий хээтэй байжээ. Мөн дуганы дотор болон гадна ханыг цагаан пайтуугаар өнгөлсөн байжээ. Цогчин дуган нь боржин чулуун суурь бүхий 10-н тулгуур баганатай, мод болон чулуун шалтай, дотроо ус

зайлуулах сувагтай байжээ.

### Хосгүй үнэт олдворууд

ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс эрхлэн гаргасан “Номын их хүрээг нээсэн нь: Сарьдагийн хийдийн судалгаа”-наас үзэхэд энэхүү хэрэм хана бүхий гол Цогчин дуганы баруун болон зүүн хойд буланд нь суугаа байдалтай 4 метрийн өндөртэй 2 шавар бурхан, баруун зүүн хана дагуу тус бүр 5, 5-н томоохон шавар бурхад байсны ул мөрүүд тус тус олджээ. Баруун хойд буланд байсан суугаа бурханы шүншигнээс дөрвөн хөлт тулга, тулга дээрх хүрэл тогоо, тогооны дотор талд шаазан бумба, цул мөнгөн аяга, олон өнгийн эрдэнийн чулуугаар хийсэн эрхины ширхэгүүд, мөнгөн зоос, нимгэн ялтсан хуудас алт (*сааз алт*), будааны төрлийн ургамлууд, том ясан үртэй жимсний үлдэгдэлүүд олдсон байна.

Мөн тогооны дээр олон хэсэг тасарч хоорондоо наалдсан, боловч тэнийлгэж үзэх боломжтой, дээр нь “Замбал” бурхны эр, эм сахиусан хүрд урласан нимгэн мөнгөн хуудас олдсон байна. Уг тулганы дор ган дөш булсан байсныг олжээ. Тулга тогооны хойд талд XVII зууны үеийн Монгол “баатар эрийн бүрэн хэрэглэл болох ялтсан хуяг, ялтсан шилэвч бүхий төмөр дуулга, илд, зэв, жадны гилбэр, цахиур гар буу” (Эрэгзэн Г, 2015, х.10) зэргийг байрлуулсан нь малтлагийн үеэр илэрчээ. Мөн уг дуганы малтлагаас 1 метрийн голчтой бурханы суурь олдсон бөгөөд түүний урд талд байрлуулсан модон хашлага дээр шавраар хийсэн өлзийт найман тахил, дөрвөн хос загас, бумба, бадам цэцэг, найман хэгээст алтан хүрд зэрэг хосгүй үнэ цэнэтэй олдворууд олджээ.

Уг дуганы малтлагын гүн 3 м гаруй болох үед бадам цэцгийн суурин дээр завиан сууж буйгаар урласан нэг бүрийн өндөр нь 15 см шавар бурхадны баримлууд маш олноор олдсон байна. Эдгээр нь Өндөр гэгээн Занабазарын дэг сургуулиар урласан Язгуурын таван бурхан гэдэг нь тодорхой болсон байна. Цогчин дуганы байгууламж нураагдах үед дарагдаж, эвдэрч хэмхэрсэн байдалтай илэрсэн дээрх Язгуурын 5-н бурхадны зарим нь бүтэн, зарим нь мутар, толгой нь тасарч унасан байх ба одоогоор 1300 орчим олоод байна. Эдгээр бурхад нь урдаа давхар бадам цэцгийн хээтэй суурин дээр завиан суугаад амарлангуй дүрээр гүн бясалгал үйлдэж байгаа шинжтэй дүрслэгджээ. Бурхадны мэлмий харц нь доошоо харж буйгаар дүрслэгдсэн ба бурхад бүр яг л амьд хүн шиг дотоод сэтгэлийн хөдлөл нь илрэх мэт ер бусын сэтгэгдэл төрүүлэх ажээ. Бурхадны мутрын байрлал өөр өөр байх ба дор бүрнээ сонгодог тиг, хэмжээ харьцаатай, нарийн

уран хийцтэй, цөм нэг хүмүүний гараар урлагдсан мэт харагддаг.

Дээрх язгуурын таван бурхад нь тухайн цагт сүм дуганы дотоод чимэглэлийн зориулалтаар бүтээгдсэн бөгөөд магадгүй сүүлд нь алт, гуулиар шарахаар төлөвлөж байсан ч болох талтай. Учир нь өндөр гэгээний мутраар бүтээгдсэн яг ийм хийцтэй алтан шармал бурхадууд өдгөө Дүрслэх Урлагийн Музейн санд хөмрөгт хадгалагдаж байдаг. Мөн тал хэвэнд цутгасан “Ямантаг”, “Ногоон дарь эх”, “Аюуш” зэрэг 20 гаруй шавар бурхад уг малтлагын явцад илэрчээ. Эдгээр тал хэвэнд цутгасан бурхадны дүрийн гадуурх хүрээ нь хоёр янзын хэлбэртэй бөгөөд нэг хэсэг нь дугуй хүрээтэй бөгөөд түүн дотроо бурхадны дүрийг хагас товгор, энгэмэл хэлбэрээр товойлгон дүрсэлсэн байдаг. Удаах нь чандманлан гурвалжин хүрээтэй агаад бурхадны бие лагшинг нааш нь товойлгон дүрслэн гаргасан байна. Хүрээний дотуур ирмэг дагуу тарнийн түвд үсгүүдийг төвийлгөн гаргажээ.

Мөн уг малтлагаар дээврийн хагархай ваарууд, хөвөө эмжээр, алтадмал ганжир оройн хэлтэрхий, барилгын шавар хийц, тоосгоны хэлтэрхий, олон төрлийн зориулалттай төмөр хадаасууд (*модон тулгуур багана ба дам нурууг бүслүүрдэх г.м.*), сүм дуганы хаалганы босгон дээр хадаастай байсан нимгэн төмөр, хаалганы цүү, цуурга, нугас, чимэглэлийн төмөр хийцүүд зэрэг олдворууд ихээр олдсон байна. Эндээс үзэхэд XVII зууны тэр цаг үед Монголчууд ханын тоосго, дээврийн ваар, хадаас, нугас, цуурга зэрэг төмөр хийцүүд зэрэг хэрэгцээт барилгын материалуудаа өөрсдөө хийдэг байсан нь нотлогдож байна. Уг Цогчин дуганы малтлагаас илэрсэн дээрх олдворуудын илэрсэн байдлаас ажиглахад Өндөр гэгээн Занабазарын байгуулсан энэхүү Төгсбаясгалант Номын Их хүрээ буюу Цагаан хот нь гэнэтийн их дайралтанд өртөж, эмх замбараагүй үймээн, галдан шатаалтын хөлд нураагдан үлдсэн нь тодорхой байдаг. Учир нь сүм дуганы дээвэр, чулуун хананы нурсан байдал, галд шатсан модон багана, дам нурууд, шалны банзнуудын үлдэц нь гал түймэрт өртөн нураагдсаны илрэл юм. Мөн Цогчин дуганы доторх бурхан шүтээн, тахилын эд зүйлс, чимэглэлийн зүйлс цөм л гэнэтийн нуралтын үед цохигдож хагарсан, эвдэрсэн байдалтайгаар тэр чигтээ дарагдаж үлдсэн нь олдворуудын байгаа байдлаас илт харагдаж байна.

Уг судалгааны ажлын явцад нэгэн таамаглал дэвшүүлж буйгаа энд онцлоход тухайн цагт Шарын шашны томоохон сүм хийдүүдийг барьж дууссаны хойно тухайн сүм хийдийг бүхэлд нь болон эргэн тойрны газар, байгалийн тогтоцтой хамтатган өвөрмөц орон зайн дүрслэлтэйгээр зохиомжлон томоохон хэмжээтэй зурж үлдээсэн байдаг. Тухайлбал: Марзан Шаравын “Богдын

өвлийн ордон”, Г.Дамбын зурсан “Заяын хүрээ”, бүтээгч нь тодорхойгүй “Балданбэрээвэн хийд”, “Их хүрээ” зэрэг олон бүтээлүүд манай музейдэд хадгалагдаж байдаг. Тэр дунд Дүрслэх урлагийн музейн сан хөмрөгт бүтээгч, бүтээгдсэн хугацаа, нэр нь тогтоогдоогүй “Эртний Монголын уран барилга” нэрээр хадгалагдаж буй бүтээл нь “Төгсбаясгалант” Номын их хүрээний зураг байж болзошгүй юм. Учир нь дээрх зурагны сүм хийдүүдийн барилгын загвар хийц, ерөнхий байр байдал, Цогчин дуганууд гадуураа хэрэмтэй байгаа зэрэг нь Номын их хүрээтэй ойролцоо, төсөөтэй байгаа юм.

## Дүгнэлт

Энэхүү “Төгсбаясгалант Номын Их Хүрээ”, -Цагаан хотын туурь нь Монголын дүрслэх урлагийн түүхэн хөгжлийн тодорхой нэгэн үеийг төлөөлсөн түүх, соёлын хосгүй үнэт уран барилга, уран баримлын дурсгал хэмээн үзэж байна. Учир нь одоогоор зөвхөн гол Цогчин дуганд л археологийн малтлага хийсэн бөгөөд эндээс илэрсэн олдворууд нь Өндөр гэгээн Занабазарын дэг сургуулиар өөрийн гараар урласан ахин давтагдашгүй ур хийцтэй, хосгүй нандин бүтээлүүд болох нь нотлогдож байна. Иймд цаашдаа уг хотын тууринд бүхэлд нь археологийн судалгаа явуулж, олдвор бүтээлийг бүртгэлжүүлж, мэргэжлийн байгууллагаар нь сэргээн засварлуулан, хойч үедээ өвлүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Халхын Өндөр гэгээн Занабазар нь уран барималч, зураач, хэл шинжлэгч, шашин, төрийн зүтгэлтэн байсан төдийгүй чадварлаг архитектор байсан хэмээн үзэж болохоор байна. Тэрбээр бурхны шажин соёлыг ард олонд түгээх болон шашны урлал, бүтээл туурвих зориулалтаар сүм хийдүүдийг Монгол орон даяар олноор барьж байгуулах үйл хэргийг эхлүүлж байсан нь тодорхой болж байна. Чухамдаа түүний гардан байгуулж, бурхан шүтээнүүдийг нь биечлэн өөрөө бүтээсэн энэхүү “Төгсбаясгалант - Номын Их Хүрээ” нь Өндөр гэгээний цэл залуу 20 наснаас 51 нас хүртэлх ид хийж бүтээх үедээ цогцлоосон, ур ухаан хосолсон агуу их туурвилын нэгэн тод жишээ байсан ажээ.

## Ашигласан материал

- Батбаяр, Б. (2006). Монголчууд: *Нүүдэл суудал I дэвтэр*. Улаанбаатар.
- Болд, Б. (2008). *Монголын уран барилгын чимэглэл*. Улаанбаатар.
- Болдбаатар, Ж. (2010). *Монголын Бурханы шашны лам хувраг*. Улаанбаатар.

- Бира, Ш. (1995). Зая бандид Лувсанпэрэнлэй. *Өндөр гэгээний намтрууд оршивай*. Улаанбаатар.
- Даажав, Б. (2006). *Монголын уран барилгын түүх. тэргүүн дэвтэр*. Улаанбаатар.
- Дамдинсүрэн, Д. (1995). *Их хүрээний нэрт урчууд*. Улаанбаатар.
- Дэндэв, Л. (2008). *Дундад үеийн Монголын түүх*. Улаанбаатар.
- Жавзандамбын анхны төрлийн нэр оршивай*. (он т-бус). Гар бичмэлийн сан, жинхэнэ эх, гар бичмэл. Монголын үндэсний номын сан. Улаанбаатар.
- Майдар, Б. (1971). *Архитектура и градостроительство Монголии*. Москва.
- Түүхийн хүрээлэн. (2003). *Монгол улсын түүх*. Боть IV. Улаанбаатар.
- Оюунбилэг, З. (2010). *Амарбаясгалантын архитектур*. Улаанбаатар.
- Өлзий, Ж. (1990). *Манзуширийн хийдийн сүм дуган. Дүрслэх урлаг – Уран барилга. сэтгүүл*, Улаанбаатар.
- Ринчен, Б. (1956). *Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл*. Улаанбаатар.
- Шархүү, С. (2005). *Монголын уран барилгын материалын боловсруулалт, ашиглалтын түүхэн уламжлал*. Улаанбаатар.
- Энхдаваа, С. (2000). *Монголхээ чимэг*. Улаанбаатар.
- Эрэгзэн, Г. (2015). *Номын их хүрээг нээсэн нь: Сарьдагийн хийдийн судалгаа. ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн. Үзэсгэлэнгийн каталоги*. Улаанбаатар.